

## БИЧИЛ ЗЭЭЛ ОЛГОХ ЗӨВЛӨЛД ЗОРИУЛСАН ЕРӨНХИЙ УДИРДАМЖ.

Бүх бичил зээлийн хүсэлтүүд нь УРГАХ ЦАГ ТББ-ийн орон нутгийн зөвлөлүүд эсвэл тухайн орон нутгийн зөвлөл ажиллахгүй нөхцөлд УРГАХ ЦАГ-ийн зөвлөл ба гүйцэтгэх захирлаар шалгагдсан байна. Шинэ бизнес эхлүүлэхэд зориулсан ба бизнесээ өргөжүүлэхэд зориулсан зээлүүд нь доорх удирдамжаар зохицуулагдана. Зээлийн хэмжээ нь ерөнхийдөө 500\$ -с бага байх ба харин илүү өндөр зээл авах зохистой байгаа бизнесийг авч хэлэлцэх боломжтой. Зээл нь бизнесийн ердийн үйл ажиллагаануудад зарцуулагдах боломжгүй. Зээл нь бизнесийн ердийн үйл ажиллагаа болох (цалин болон эсвэл үйл ажиллагааны урсгал зардлууд)-д олгогдож болохгүй.

### **I. Зээлийн хүсэлтүүд**

Бүх зээлийн хүсэлтүүд нь зээл хүсэгчээр өөрөөр нь танилцуулагдсан байх ёстой ба доорх бүх дагалдах бичиг баримтуудыг багтаасан байх хэрэгтэй.

1. Зээлийн зорилгын баримт ба шаардагдах зээлийн хэмжээ (төгрөгөөр). Зорилгын баримт нь бүрэн байх хэрэгтэй ба зээл хүсэгчээр баталгаажиж гарын үсэг зурагдсан байх хэрэгтэй.
2. Бизнес төлөвлөгөөг зээл авахыг хүсэгч гүйцэтгэсэн байх.  
Бизнес төлөвлөгөө нь *Библи дээр Суурилсан Бизнесийг Эхлүүлэх нь: Дасгалын ном 1-ийн* хавсралт дээрх бизнес төлөвлөгөөний загвар дээрхи бизнесийн шаардлагуудыг хангасан байх.
3. Шинэ бизнес эхлүүлж байгаа тохиолдолд бизнесийн зээл хүсэгч Зах зээлийн судлагаагаа баримтын нотолгоотойгоор хийж бичил бизнесийн зээл олгох зөвлөлд танилцуулах ёстой.
4. Орон нутгийн удирдлагын санал /тодорхойлолт/ зээлийн хүсэлтийн тулгуур болж өгнө.
5. Пасторын санал тодорхойлолт (хэрвээ зээл авахыг хүсэгч сүм чуулганы гишүүн бол шаардлагатай).
6. Газар эзэмших гэрчилгээ. Хот орон нутаг ялгаатай.
7. Банкны өр зээл байхгүй гэсэн тодорхойлолт /500.000 төгрөгөөс дээш зээл олгох тохиолдолд/
8. Санхүүгийн үүрэг хариуцлагын баримт бичиг нь Зээл авахыг хүсэгч хувийн ямар нэг өрийн данс тооцоо байхгүй байх. Энэ нь зээл хүсэгчээр баталгаажуулагдан гарын үсэг зурагдаж, он сар нь тавигдсан байх шаардлагатай.
9. Зээл авахыг хүсэгч Ургах цаг байгууллагын жижиг бизнесийн сургалтанд амжилттай сурч төгссөн Гэрчилгээг авсан байх.
10. Зээлийн батлан даагч 2 хүний нэрс болон хаягууд. Зээл хүсэгчийн хамт амьдардаг хамаатан садан биш байх ёстой, тустай амьдардаг бол харгалзан үзнэ.

### **II. Зээл олгох зөвлөлийн шийдвэр**

1. Хүсэлт гаргагчийн Бизнес Төлөвлөгөө, Зах зээлийн судалгаа ба Бизнесийн санхүүгийн мэдээллүүд зээл олгох зөвлөлд нэг бүрчлэн нарийвчлан бизнес хийх чадвартай эсэх нь шалгагдсан байх ёстой. Зээл олгох зөвлөл нь зээл хүсэгчээс илүү мэдээллийг шаардах боломжтой. Хэрэв зээл олгох зөвлөл нь

- зээлийн эргэн төлөлтөнд сэтгэл хангалуун бус байвал зээл олгогдохгүй байж болно.
2. Салбарын төлөөлөгч (Зээл олгох зөвлөлийн нэг гишүүн) Зээлийн зөвлөлийг төлөөлөн дор хаяхад зээл авахыг хүсэгчийн гэрт очсон байх ёстой ба бизнес хийх гэж байгаа газар Зээл хүсэгчийн нөхцөл байдлыг тодорхойлох Зээлээ эргэн төлөлтөнд эдгээр зүйлс нь нөлөөлж байгаа эсэхийг тодорхойлсон байх ёстой. Эдгээр зүйлсийг очиж үзэн тодорхойлоогүй тохиолдолд ямар ч зээл олгох шийдвэр гарахгүй байх болно.
  3. Зээл олгох зөвлөлийн шийдвэр санал нэгтгэйгээр баталгаажсан байх ёстой.
  4. Зээл олгох зөвлөл шийдвэрээ түүнийхээ учир шалтгаануудаа зээл хүсэгчид бичгээр мэдэгдэх ёстой.
  5. Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхийн тулд зээл хүсэгчтэй хаматай хэн нэгнийг Зээл олгох Зөвлөлийн гишүүн байлгаж болохгүй. Хэрвээ ямар нэг байдлаар тийм тохироо бүрдвэл зээл олгох зөвлөлийн гишүүнд шийдвэр гаргах санал хураалтанд оролцохгүй ба орон нутгийн нэр хүнд бүхий өөр хүн зээл олгох зөвлөлийн шийдвэр гаргахад оролцох боломжтой.
  6. Зээл олгох зөвлөл 7 хоногийн дотор зээл олгох үгүй эсэхийн эцсийн шийдвэр гаргана.

### **III. Зээлийн зохицуулалт**

1. Хэрвээ зээл олгох зөвлөл зээл олгохыг зөвшөөрвөл, Зээлийн гэрээ хийгдэх болно. Зээл олгох зөвлөлийг төлөөлөн нэг гишүүн нь болон Зээл хүсэгч нараар баталгаажуулагдан гарын үсэг зурагдаж үүнээс үүдэлтэйгээр Зээлдэгч сүүлд нь нотариатаар баталгаажуулна.
2. Зээлийн гэрээ нь дараах нарийвчилсан зүйлсийг багтаана:
  - i. Зээлийн хэмжээг баталгаажуулна.
  - ii. Зээлийн хугацаа (ихэвчлэн 12 сар түүнээс бага).
  - iii. Эргэн төлөлтийн хуваарийг зөвлөл зээлдэгчтэй ярилцан гаргана.
  - iv. Зээлийн төлбөр (хүү) болон (одоогоор Ургах цаг байгууллагын удирдамжийн дагуу)
  - v. Хугацаандаа төлөгдөөгүй эргэн төлөлтөнд шийтгэл оноох алданги тооцох
  - vi. Зээлдэгч ба Зээл олгох зөвлөлийн Үүрэг зээлийн хугацаанд харилцан бие биетэйгээ холбоотой ажиллана.
3. Зээлийн гэрээ Зээл олгох зөвлөлд хадгалагдах ба зээл хүсэгчид нэг хувь өгөгдсөн байна.
4. Зээл олгох зөвлөл ба зээл хүсэгч хоорондын холбоо
  - i. Салбарын төлөөлөгч (ихэвчлэн зээл олгох зөвлөлийг төлөөлөн гарын үсэг зурсан) зээл олгосон хугацааны туршид зээл хүсэмжлэгчтэй холбоотой ажиллах үндсэн үүргийг хүлээнэ.
  - ii. Томилогдсон Зээл олгох салбарын төлөөлөгч дор хаяхад сард нэг удаа зээлдэгчтэй холбоо барьсан байх хэрэгтэй - бизнесийн байраар нь очих эсвэл зээлдэгчид ямар нэг зээлийн эргэн төлөлтийн асуудал тулгарах эсвэл тулгарах аюулыг харвал тэр даруй зээл олгох зөвлөлд сэрэмжлүүлэн мэдэгдэх хэрэгтэй.
5. Зээл бүтнээрээ эргэн төлөгдвөл Салбарын төлөөлөгч зээлийн өргүй гэсэн Гэрчилгээг зээлдэгчид олгох хэрэгтэй.
6. Зээл олгох зөвлөл гурваас доошгүй гишүүнтэй байх ёстой.